


БАТЛАВ:

БАТЛАВ:



## 150 ОРТОЙ ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ГЭРЭЭ

Улаанбаатар хот

№

2024 он 04 сар 30 өдөр

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Монгол Улсын Иргэний хууль, Иргэний Барилгын тухай болон зураг төсөл боловсруулах, зөвшөөрөлгөх, батлах дүрэм БНбад 11-01-98, бусад хууль, тогтоомжийн дагуу зураг төсөл боловсруулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан үүрэг хүлээх, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний зорилго оршино.

1.2 Нэг талаас захиалагч "Ховд аймаг Жаргалант сумын 4 дүгээр цэцэрлэгийг төлөөлж эрхлэгч З.Энхцэцэг /цаашид "Захиалагч" гэнэ/ нөгөө талаас "Өсөн үржих констракшн" ХХК-г төлөөлж архитектор Ц.Нямсүрэн /цаашид "ажил гүйцэтгэгч" гэнэ/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.3 Энэхүү гэрээ нь зураг төсөл боловсруулах ажлын чанар, үнэ, хугацааг эцэслэн тохирох үндэслэл болно.

1.4 Захиалагчийн хүсэлтээр "Ховд аймаг Жаргалант сумын 4 дүгээр цэцэрлэг"-н 150 ортой цэцэрлэгийн барилгын иж бүрэн зураг төслийг 2024 оны 05 сарын 01 өдрөөс 2024 оны 06 сарын 15 өдөр хүртэл хугацаанд барилгын зураг төслийн "Өсөн үржих констракшн" ХХК хариуцан хийнэ.

1.5 Энэхүү гэрээт ажлыг гүйцэтгэхтэй холбогдон захиалагч гүйцэтгэгчийн хооронд хийсэн уулзалт ярилцлага, асуудалтай зүйлийг ярилцаж шийдсэн шийдлийн тэмдэглэл, протоколийг тогтмол хөтөлж гэрээнд гарын үсэг зурж баталсан хүмүүсээр зөвшөөрүүлэн гарын үсэг зуруулж гэрээний биелэлтийг дүгнэхдээ баримт болгон хавсаргана.

### Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

2.1 Зураг төсөл зохиоход шаардлагатай дараах зүйлүүдийг гүйцэтгэгчид хүлээлгэн өгнө.

- А. Архитектур төлөвлөлтийн даалгавар /Зургийн даалгавар/  
Б. Техникийн нөхцөл /Дулаан, Цэвэр бохир ус, Цахилгаан, Холбоо/  
В. Газрын гэрээ, гэрчилгээ, кадастрын зураг

2.2 Зураг төсөл боловсруулах явцад өөрсдийн саналаар нэмэлт өөрчлөлт оруулах буюу гэрээний хугацааг өөрчлөх, гэрээг цуцлах шаардлага гарвал гүйцэтгэгчтэй хамтран гэрээг дүгнэж, гүйцэтгэсэн ажлын хэмжээнд санхүүжилт хийж асуудлаа эцэслэн шийдвэрлэнэ.

2.3 Зураг төсөл зохиож дуусаад гэрээнд заагдсан ажлууд хийгдэж дууссаны зураг төслийг актаар 2 хувь хүлээн авна.

2.4 Зураг төсөл гэрээ, протоколд заасны дагуу хийгдээгүй бол засварлуулах, бүрэн хийлгэх талаар гүйцэтгэгчид санал, шаардлага тавих, өгсөн саналыг гүйцэтгэгч хүлээн авахгүй байгаа нөхцөлд зураг төслийн тохиролцсон үнээс хасаж санхүүжүүлэх, гүйцэтгэчийг өөрчлөх эрхтэй.

2.5 Төслийн шатанд хийгдэж байгаа зураг төслийг барилга барихаас өөр нөхцөлөөр өөрөөр хэлбэл төлөвлөлтийг анхааран харах, материалын тооцоо гаргах гэх мэт шалтгаанаар зураг төсөл хийгдэж байх явцад авч үзэж болно.

### **Гурав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

3.1 Зураг төслийн ажлын архитектур төлөвлөлт, инженерийн болон техник технологийн шийдлийг шинжлэх ухаан техникийн дэвшилтэй уялдуулан өөрийн орны нөхцөлд тохируулан шийдэхийн хамт Монгол Улсад дагаж мөрдөж буй зураг төслийн ажлын техникийн нөхцөл, стандарт, барилгын норм ба дүрмийн шаардлагыг хангасан байна. Зураг төсөл боловсруулах, зөвшөөрөлцөх, батлах дүрэм /БНбаД 11-01-98/-ийг баримтлан зураг төслийн ажлыг гүйцэтгэнэ.

3.2 Барилгын зураг төслийн ажлын иж бүрдэлд дараах ажлууд орно. Үнд:

Барилгын дотор талд

3.2.1 БА /барилга архитектур/

3.2.2 ББ /барилга бүтээц/

3.2.3 ХАС /халаалт агаар сэлгэлт/

3.2.4 ЦБУ/цэвэр бохир ус/

3.2.5 ХТ, ДГ /цахилгаан/

3.2.6 ЕТ /ерөнхий төлөвлөгөө/

3.2.7 Төсөв, ажлын тоо хэмжээ, материалын тоо хэмжээ

3.2.8 Загвар зураг

Барилгын гадна талд

3.2.9 ГД /гадна дулаан/

3.2.10 ГЦБУ /гадна цэвэр бохир ус/

3.2.11 ГЦ /гадна цахилгаан/

3.2.12 ГХ /гадна холбоо/

3.3 Захиалагчийн хүсэлтээр хоёр тал тохиролцсон нөхцөлд нэмэлт ажил гүйцэтгэж болно. Үнд: /техник эдийн засгийн үзүүлэлт, тооцоо судалгаа, газрын дэвсгэр зураг бэлдэх, зургийн диаалгавар боловсруулах/.

3.4 Гэрээт ажлаа гүйцэтгэхийн тулд тусган гүйцэтгэгч авах шаардлага гарвал түүнтэй гэрээ байгуулж ажиллах ба тусган гүйцэтгэгчийн ажлын үр дүнг гүйцэтгэгч захиалагчийн өмнө хариуцана.

3.5 Гүйцэтгэгч барилгыг баригдах явцад зохигчийн хяналтыг зайлшгүй хийх ба энэ тухайгаа гэрээгээр зохицуулна.

### **Дөрөв. Хугацаа, төлбөр тооцооны талаар**

4.1 Зураг төслийн ажлын нийт үнэ **49 500 000 /дөчин есөн сая таван зүүн мянган/** төгрөг төлөхөөр харилцан тохиров.

4.2 Зураг төслийн үнийг төндөрт шалгарсан гүйцэтгэгчийн эхний гүйцэтгэлээс олгохоор тохиров

4.3 Захиалагч болон гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлээгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд зураг төсөл боловсруулах ажлын тохиролцсон үнийн 0.01 хувиар буруутай талдаа алданги ноогдуулна. Алдангийн нийт хэмжээ зураг төслийн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50%-с хэтрэхгүй байна.

### **Тав. Харилцаа, хугацаа**

5.1Талууд гэрээний биелэлттэй холбогдсон асуудлаар асуудалдтай зүйлүүд гарвал аль аль талын эрх ашигт нийцсэн шийдэлд хүрэхийг эрхэмлэх бөгөөд тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шуухэд нэхэмжлэл гаргана. Техникийн нөхцөл гарахтай холбогдуулан гэрээний хугацааг харилцан тохиролцож болно.

5.2 Энэхүү гэрээг 2024 оны 04 сарын 30-ны өдөр 2% үйлдэж, захиалагч, гүйцэтгэгч тус бүр нэг хувийг хадгалав.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**ЗАХИАЛГАГЧ:**

ХОВД АЙМАГ ЖАРГАЛАНТ СУМЫН 4  
ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ

.....3. ЭНХЦЭЦЭГ

Хаяг: <sup>06</sup>Ховд <sup>1</sup>Жаргалант сумын 4 дүгээр  
цэцэрлэг Цамбагарав багийн 8 гудам 10 тоот

Имэйл: [enhce7115@gmail.com](mailto:enhce7115@gmail.com)

Утас: 99437115, 88687115

Регистр: 9069445

**ГҮЙЦЭТГЭГЧ:**

ӨСӨН ҮРЖИХ КОНТРАКЦИН ХХК  
АРХИТЕКТОР

Ц.НЯМСҮРЭН

Хаяг: Баянгол дүүрэг, 15-р хороо.

Хасбаатарын гудамж. 32б-2 тоот

Имэйл: [OUK108791@gmail.com](mailto:OUK108791@gmail.com)

Утас: 76098791, 99108233

Харилцах данс: Хаан Банк 5175101898

Регистр: 6391931